

**ХУУЛЬ, УЛСЫН ИХ ХУРЛЫН БОЛОН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛООР
ЗАСГИЙН ГАЗАРТ ҮҮРЭГ ӨГСӨН ШИЙДВЭРИЙН
2016 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАНИЛЦУУЛГА**

/Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны
эрхлэх асуудлын хүрээнд/

2017.06.12

Улаанбаатар хот

НЭГ. ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1 дэх хэсэгт “Засгийн газрын гишүүд хагас жил тутам хууль тогтоомж, Улсын Их Хурлаас баталсан бодлогын баримт бичгийн болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, тухайн жилийн төсөв, үндсэн чиглэлийн хэрэгжилтийн талаархи тайланг холбогдох Байнгын хороонд ирүүлнэ” гэж заасан байдаг.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн тайланд шинжилгээ хийж, ирүүлсэн санал дээр үндэслэн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд гаргасан хууль тогтоомжийн заалтыг хяналтаас хасах саналыг хавсарган хүргүүлж байна.

“Хууль, Улсын Их Хурлын болон Байнгын хорооны тогтоолоор Засгийн газарт үүрэг өгсөн шийдвэрийн хэрэгжилтийн 2016 оны жилийн эцсийн байдлаар ирүүлсэн танилцуулга”-ыг Улсын Их Хурлын www.parliament.mn цахим сүлжээнд байршуулсан болно.

ХОЁР. МОНГОЛ УЛСЫН ХУУЛИАР ЗАСГИЙН ГАЗАР БОЛОН ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮДЭД ҮҮРЭГ ӨГСӨН ЗААЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР

2.1. Монгол Улсын хуулийн хэрэгжилт

Засгийн газар болон Засгийн газрын гишүүдэд хууль хэрэгжүүлэхтэй нийцүүлэн холбогдох дүрэм, журам, жагсаалтыг батлан гаргах үүрэг өгсөн Монгол Улсын 68 хуулийн 262 заалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд бүртгэж, хяналтанд авсан.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2016 оны жилийн эцсийн байдлаар Монгол Улсын 111 хуулийн 376 заалтын хэрэгжилтийн мэдээг ирүүлсэн нь хяналтанд авсан нийт хуулийн 44 буюу 64.7 хувь, 204 заалт буюу 77.9 хувийнх нь хэрэгжилтийн мэдээг ирүүлсэн байна. Үлдсэн 67 хуулийн 172 заалтын хэрэгжилтийн мэдээний хувьд Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас өмнөх онуудад бүрэн хэрэгжиж, хяналтнаас хассан хуулийн хэрэгжилтийн мэдээнүүд болно.

Мэдээнээс үзэхэд давхардсан тоогоор 77 хуулийн 170 заалт буюу 45.3 хувь нь хэрэгжсэн, 56 хуулийн 148 заалт буюу 39.4 хувь нь хэрэгжих шатанд байгаа, 5 хуулийн 9 заалт буюу 1.5 хувь нь хэрэгжээгүй, 11 хуулийн 29 заалт буюу 7.8 хувь нь хугацаа болоогүй, 13 хуулийн 17 заалт буюу 4.5 хувь нь үнэлгээгүй, 2 хуулийн 2 заалт буюу 0.5 хувь нь хүчингүй болсон байна.

2.2. Монгол Улсын хуулиар Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газар болон Засгийн газрын гишүүдэд үүрэг өгсөн заалтын хэрэгжилт

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газарт үүрэг өгсөн Монгол Улсын 2 хуулийн 4 заалтыг Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд бүртгэж, хяналтанд авсан.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2016 оны жилийн эцсийн байдлаар тус Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд 4 хуулийн 6 заалтын хэрэгжилтийн мэдээг ирүүлснээс 1 хуулийн 2 заалт буюу 33.3 хувь нь хэрэгжсэн, 3 хуулийн 3 заалт буюу 50.0 хувь нь хэрэгжих шатанд, 1 хуулийн 1 заалт буюу 16.7 хувь нь үнэлгээгүй ирсэн байна.

Монгол Улсын хуулийн хэрэгжилтийн мэдээг хүснэгтээр үзүүлбэл:

	Хууль /Давхардсан тоогоор/	Заалт	
		Тоо	Хувь
Хяналтанд авсан	2	4	100.0
Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн	4	6	
Үүнээс:			
- Хэрэгжсэн	1	2	33.3
- Хэрэгжих шатанд	3	3	50.0
- Үнэлгээгүй	1	1	16.7

2.3. Мэдээнд гарсан зөрчил

1. Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.10-т заасан “Цөмийн болон цацрагийн хяналтын улсын байцаагч, цацрагтай ажиллагч нь ажлын онцлогт тохирсон тусгай хувцас, ялгах тэмдэг хэрэглэх бөгөөд ажлын тусгай хувцасны загвар, хэрэглэх журам, эдэлгээний хугацааг Цөмийн энергийн комисс батална” гэсэн заалтын хэрэгжилтийг дахин үнэлж ирүүлээгүй байна.
2. Мөн 2016 оны хагас жилийн байдлаар бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасах саналтайгаар ирүүлж байсан 1 хуулийн 2 заалтыг дахин хяналтаас хасах саналтайгаар ирүүлсэн байна. Үүнд: Тагнуулын байгууллагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 10 дугаар зүйлийн
 - 10.5-т заасан “Монгол Улсын Зэвсэгт хүчний дээд удирдлагыг цэрэг-улс төрийн болон цэрэг-стратегийн тагнуулын мэдээгээр хангах чиг үүргийг Тагнуулын ерөнхий газрын цэргийн тагнуулын газар хэрэгжүүлэх бөгөөд тус газрын дүрэм, ажиллах журмыг Тагнуулын ерөнхий газрын дарга, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргатай хамтран батална.”;
 - 10.6-д заасан “Хил хамгаалах байгууллагын дээд удирдлагыг хил орчмын нөхцөл байдлын талаарх тагнуулын мэдээгээр хангах чиг үүргийг Тагнуулын ерөнхий газрын хилийн тагнуулын газар хэрэгжүүлэх бөгөөд тус газрын дүрэм, ажиллах журмыг Тагнуулын ерөнхий газрын дарга, хил хамгаалах байгууллагын даргатай хамтран батална.” гэсэн заалтын хэрэгжилтийг дахин хяналтаас хасах саналтай ирүүлжээ.
3. 2016 оны жилийн эцсийн байдлаар 2 хуулийн 2 заалтын хэрэгжилтийг

бууруулан ирүүлсэн байна. Тухайлбал,

- Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэглээний эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-т заасан “Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн үйлдвэрийн болон хадгалах байр, агуулах дахь аюулгүй ажиллагааны журмыг геологи, уул уурхайн болон батлан хамгаалахын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага мэргэжлийн хяналтын төв байгууллагатай хамтран батална” гэсэн заалтын хэрэгжилтийг 2016 оны эхний хагас жилийн байдлаар 70 хувьтай ирүүлж байсан бол 2016 оны жилийн эцсийн байдлаар 10 хувийн хэрэгжилттэй гэж ирүүлэн хэрэгжилтийн хувийг буурсан байна.
- Гүйцэтгэх ажлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.5-т заасан “Гүйцэтгэх байгууллагын бие бүрэлдэхүүнийг нь нууцалбал зохих салбар, нэгжийн үйл ажиллагааны төсвийг төлөвлөх, санхүүжүүлэх, гүйцэтгэлийг нь тайлагнахад баримтлах журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, тагнуулын төв байгууллагын даргатай хамтран батална” гэсэн заалтыг 2016 оны эхний хагас жилийн байдлаар бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасах саналтай ирүүлэн, хяналтаас хасагдсан бол 2016 оны жилийн эцсийн байдлаар хэрэгжилтийг бууруулан 90 хувийн хэрэгжилттэй ирүүлсэн байна.

ГУРАВ. УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР

3.1.Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилт

2016 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газарт үүрэг өгсөн Улсын Их Хурлын нийт 83 тогтоолын 303 заалтыг Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд, бүртгэж хяналтанд авсан.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2016 оны жилийн эцсийн байдлаар Улсын Их Хурлын нийт 74 тогтоолын 194 заалтын хэрэгжилтийн мэдээг ирүүлсэн бөгөөд 9 тогтоолын 109 заалтын хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй байна.

Хэрэгжилтийн мэдээг ирүүлсэн 74 тогтоолын 194 заалтын 98 заалт буюу 50.5 хувь нь бүрэн хэрэгжсэн, 73 заалт буюу 37.6 хувь нь хэрэгжих шатанд, 11 заалт буюу 5.7 хувийн хэрэгжих хугацаа болоогүй, 2 заалт буюу 1.0 хувь хэрэгжээгүй, 10 заалт буюу 5.2 хувь нь үнэлгээгүй ирүүлсэн.

3.2.Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилт

Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд 2016 оны жилийн эцсийн байдлаар Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээний Улсын Их Хурлын 3 тогтоолын 7 заалтыг хяналтанд авсан.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2016 оны жилийн эцсийн байдлаар Улсын Их Хурлын 5 тогтоолын 18 заалтын хэрэгжилтийн мэдээг ирүүлснээс давхардсан тоогоор 5 тогтоолын 7 заалт буюу 38.9 хувь нь хэрэгжсэн, 2 тогтоолын 10 заалт буюу 55.5 хувь нь хэрэгжих шатанд, 1 тогтоолын 1 заалт буюу 5.5 хувийн хэрэгжилтийг үнэлж ирүүлээгүй байна.

Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилтийг мэдээг хүснэгтээр үзүүлбэл:

	УИХ-ын тогтоол /Давхардсан тоогоор/	Заалт	
		Тоо	Хувь
Хяналтанд авсан	3	7	100.0
Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн	5	18	
Үүнээс:			
- Хэрэгжсэн	5	7	38.9
- Хэрэгжих шатанд	2	10	55.5
- Үнэлээгүй	1	1	5.5

3.3 Мэдээнд гарсан зөрчил

1. “Монгол Улсын цөмийн зэвсгээс ангид байх статусыг шинэ түвшинд гаргах тухай” Улсын Их Хурлын 2015 оны 60 дугаар тогтоолын
 - 1.3-т “Цөмийн аюулгүй байдлын тухай 1994 оны конвенц, ашигласан түлшний болон цацраг идэвхт хаягдлын менежментийн аюулгүй ажиллагааны тухай 1997 оны конвенц, цөмийн материалыг бичечлэн хамгаалах тухай 1980 оны конвенцийн 2005 оны нэмэлт, өөрчлөлтийн тухай протокол болон цөмийн бага хэмжээний шинэчилсэн протоколд тус тус нэгдэн орох”;
 - 1.5-т “Монгол Улсын нутаг дэвсгэрт байрлаж байгаа чичирхийллийн, нил авианий болон радионуклидын станцуудын мэдээ, мэдээллийг тус улсын хавийн орчин, газар хөдлөлтийн давтамж, ажиглагдаж байгаа хандлагыг судлах, цаашид гарч болзошгүй гэнэтийн аюулаас сэргийлэх, хөрсөн доор гарч байгаа физик бодит өөрчлөлт, түүний үр дагавар зэргийг сонирхсон бусад улс, байгууллагатай хамтран судалж ажиллах” гэсэн заалтуудын хэрэгжилт 2016 оны эхний хагас жилийн байдлаар хууль тогтоомжийн хэрэгжилтийн мэдээнд бүрэн хэрэгжиж, “хяналтаас хасах” саналтай ирж байсан.
2016 оны жилийн эцсийн мэдээнд хэрэгжилтийн агуулга өөрчлөлтгүйгээр “хэрэгжих шатанд” болж, хэрэгжилтийн мэдээг зөрүүтэй ирүүлсэн байна.
2. Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2016 оны эхний хагас жилийн мэдээнд бүрэн хэрэгжиж, хяналтаас хасах саналтай ирүүлж байсан 3 тогтоолын 3 заалтын хэрэгжилтийг дахин хяналтаас хасах саналтай ирүүлсэн байна. Үүнд:
 - “Монгол Улсын төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлого батлах тухай” Улсын Их Хурлын 2009 оны 45 дугаар тогтоолын 2 дахь заалт;
 - “Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого, хөтөлбөр батлах тухай” /Улсын Их Хурлын 2011 оны 22 дугаар тогтоолын 2 дахь заалт;
 - “Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмээний тухай” / Улсын Их Хурлын 2015 оны 76 дугаар тогтоолын 1.1 дэх заалтуудын хэрэгжилтийг дахин хяналтаас хасах саналтай ирүүлжээ.
3. “Монгол Улсын цөмийн зэвсгээс ангид байх статусыг шинэ түвшинд гаргах тухай” Улсын Их Хурлын 2015 оны 60 дугаар тогтоолын 1.4-т заасан “хөрш зэргэлдээ Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс болон Бүгд Найрамдах Казахстан Улстай цөмийн салбарт хамтран ажиллахдаа хил залгаа нутагт байгаа цөмийн байгууламжийн талаар мэдээлэл авч байх” гэсэн заалтын хэрэгжилтийг үнэлж ирүүлээгүй байна.

ДӨРӨВ.УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛЫН ТАЛААР

4.1. Байнгын хорооны тогтоолын хэрэгжилт

Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд 2016 оны жилийн эцсийн байдлаар Улсын Их Хурлын Байнгын хорооноос Засгийн газарт үүрэг өгсөн нийт 93 тогтоолын 505 заалтыг хяналтанд авснаас Засгийн газрын Хэрэг эрхлэх газар 2016 оны жилийн эцсийн байдлаар 55 тогтоолын 272 заалтын буюу хяналтанд авсан нийт заалтын 53.8 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлсэн байна.

Хэрэгжилтийн мэдээг ирүүлсэн 55 тогтоолын 272 заалтаас 42 тогтоолын 121 заалт буюу 44.4 хувь нь хэрэгжсэн, 37 тогтоолын 92 заалт буюу 33.8 хувь нь хэрэгжих шатанд, 7 тогтоолын 8 заалт буюу 2.9 хувь нь хэрэгжээгүй, 7 тогтоолын 40 заалт буюу 14.7 хувь нь хэрэгжих хугацаа болгоогүй бол 8 тогтоолын 11 заалт буюу 4.04 хувь нь үнэлээгүй ирүүлсэн байна.

4.2. Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны тогтоолын хэрэгжилт

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны Засгийн газарт үүрэг өгсөн нийт 16 тогтоолын 61 заалтыг Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд бүртгэж, хяналт тавин ажиллаж байна.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2016 оны жилийн эцсийн байдлаар тус Байнгын хорооны 10 тогтоолын 31 заалтын хэрэгжилтийн мэдээг ирүүлснээс 6 тогтоолын 12 заалт буюу 38.7 хувь нь хэрэгжсэн, 9 тогтоолын 17 заалт буюу 54.8 хувь нь хэрэгжих шатанд, 2 тогтоолын 2 заалт буюу 6.4 хувь нь хэрэгжээгүй байна.

Байнгын хорооны тогтоолын хэрэгжилтийн мэдээг хүснэгтээр үзүүлбэл:

	АБГБХ-ны тогтоол /Давхардсан тоогоор/	Заалт	
		Тоо	Хувь
Хяналтанд авсан	16	61	100.0
Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн	10	31	
Үүнээс:			
- Хэрэгжсэн	6	12	38.7
- Хэрэгжих шатанд	9	17	54.8
- Хэрэгжээгүй	2	2	6.4

4.3 Мэдээнд гарсан зөрчил

1. Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны
 - “Чиглэл өгөх тухай” 2015 оны 08 дугаар тогтоолын 2 дахь хэсэгт заасан “Батлан хамгаалах салбарын кибер аюулгүй байдлыг хангахад шаардагдах зардал болох 0,9 тэрбум төгрөгийг 2016 оны улсын төсөвт Батлан хамгаалахын сайдын багц дахь зэвсэгт хүчний хөгжлийн санд тусгах”,
 - “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 2011 оны 02 дугаар тогтоолын 1.1-т заасан “Эрх зүйн орчныг бүрдүүлэх замаар анхны хөрөнгө оруулалтаа нөхсөний дараа төрийн эзэмшлийн хувьцааны хэмжээг 50-иас доошгүй хувьд хүргэж нэмэгдүүлэх асуудлаар хөрөнгө оруулагч талтай байгуулсан гэрээний

нөхцөлийг сайжруулах талаар хэлэлцээ хийж шийдвэрлэх” гэсэн заалтууд хэрэгжээгүй байна.

2. Өмнө нь бүрэн хэрэгжиж хяналтаас хасах саналтай ирүүлж байсан “Хилийн хяналтын байгууллагуудын талаар авах арга хэмжээний тухай” /Хууль зүйн болон Эдийн засгийн байнгын хороотой хамтран баталсан/ 2009 оны 13/45/12 дугаар тогтоолын 1.7 дахь заалт болох “Ашигт малтмалын олборлолт, экспортын хэмжээ үлэмж хэмжээгээр нэмэгдэж байгаа нөхцөл байдал, стратегийн ач холбогдолтой томоохон орд газруудыг эдийн засгийн эргэлтэд оруулж байгаа зэргийг харгалзан нэвтрүүлэх хүчин чадал өндөр, шинэ дэвшилтэт технологид суурилсан авто зам, төмөр зам барих, тээвэрлэх асуудлыг шийдвэрлэх.

Ачаа болон зорчигчдын хөдөлгөөний урсгалыг төрөлжүүлэн саадгүй нэвтрүүлэх боломжтой олон улсын жишигт нийцсэн хилийн боомтыг барьж байгуулах, түүнийг дагалдсан жижиг үйлдвэрлэл, үйлчилгээний бизнесийг хөгжүүлж боомт дагасан төвлөрлийг бий болгох” гэсэн заалтын хэрэгжилтийг бууруулж 70 хувь болгон ирүүлжээ.

3. Түүнчлэн хууль тогтоомжийн хэрэгжилтийн 2016 оны хагас жилийн хэрэгжилтийн мэдээнд бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасах саналтай ирүүлж байсан 2 заалтын хэрэгжилтийг дахин хяналтаас хасах саналтай ирүүлжээ. Үүнд:

- “Хуулийн хэрэгжилтийг хангах, зөрчлийг арилгах тухай” 2009 оны 04 дүгээр тогтоолын 4 дэх заалт болох “Монгол Улсын далай ашиглах тухай хуулийг чанд мөрдж ажиллах, хуулийн хэрэгжилтийг хангах, бололцоотой арга хэмжээг авч хэрэгжүүлэх”;
- Чиглэл өгөх тухай 2015 оны 02 дугаар тогтоолын 1.9 дэх хэсэгт заасан “Монгол Улсын түүх, соёлын уламжлал, эдийн засаг, нийгмийн салбарын ололтыг гадаадад сурталчлах ажлыг идэвхжүүлэх, энэ үүднээс “Монгол Улсыг гадаадад сурталчилах хөтөлбөр”-ийг боловсруулж батлан, шаардагдах хөрөнгө, санхүүгийн асуудлыг шийдвэрлэж байх” гэсэн заалтуудын хэрэгжилтийг дахин хяналтаас хасах саналтай ирүүлжээ.

4. Чиглэл өгөх тухай 2015 оны 02 дугаар тогтоолын 1-т “Гадаад бодлогын стратегийн зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор “Гадаад бодлогын үзэл баримтлалыг хэрэгжүүлэх дунд хугацааны хөтөлбөр”-ийг үндэслэл, шаардлагыг тодорхой тусган боловсруулж батлан, уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх хөрөнгийг улсын төсөвт жил бүр тусгаж байх” гэсэн заалтын хэрэгжилтийг тайлагнахдаа “холбогдох судалгааг хийсэн, санал боловсруулж байна” гэж 10 хувь болгон үнэлж ирүүлжээ.

ТАВ. БҮРЭН БИЕЛСЭН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ЗААЛТЫГ ХЯНАЛТААС ХАСАХ ТУХАЙ

Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээн дэх хууль тогтоомжийн хэрэгжилтийн мэдээнд 2016 оны жилийн эцсийн байдлаар бүрэн биелэсэн дараах зүйл, заалтыг хяналтаас хасах саналыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн байна.

Засгийн газар болон Засгийн газрын гишүүдэд журам батлах үүрэг өгсөн 1 хуулийн 2 заалт, Улсын Их Хурлын 5 тогтоолын 7 заалт, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 6 тогтоолын 12 заалтын мэдээг ирүүлсэн байна.

Хууль тогтоомж	Хууль тогтоомжийн тоо	Заалтын тоо	Хавсралтын дугаар
Монгол Улсын хууль	1	2	Хавсралт 1
Улсын Их Хурлын тогтоол	5	7	Хавсралт 2
Байнгын хорооны тогтоол	6	12	Хавсралт 3

ЗУРГАА. САНАЛ

Засгийн газрын Хэрэг эрхлэх газар хууль тогтоомжийн хэрэгжилтийг тооцохдоо хэрэгжилт удаашралтай байгаа арга хэмжээнүүдийн шалтгаан нөхцөлийг тодруулж, тайлбарлаагүй орхигдуулах, зарим заалтын хэрэгжилтийг “үнэлээгүй ажил” гэж тайлагнах зэргээр хууль тогтоомжийн хэрэгжилтийг буруу тооцож ирүүлж байна.

Хэрэгжилтийн хувийг буруу үнэлдэг зөрчил байна. Тухайлбал, өмнө нь “бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасах” саналтай заалтын хэрэгжилтийг “хэрэгжих шатанд” болгон өөрчлөн ирүүлэх, дахин хяналтаас хасах саналтай ирүүлж байна.

Мөн хяналтанд байгаа хууль, Улсын Их Хурлын болон Байнгын хорооны тогтоолын хэрэгжилтийг ирүүлэхгүй орхигдуулах, хэрэгжилтийн мэдээг өөрчлөлтгүй ирүүлэх зэрэг нийтлэг зөрчлүүд байна. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг ирүүлэхдээ эдгээр зөрчлийг засах талаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт өгөх нь зүйтэй гэж үзэж байна.

Мэдээллийн сангийн хяналтаас хасах саналтай Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд бүрэн хэрэгжсэн хууль тогтоомжийн нийт 9 хуудас жагсаалтыг хавсаргав.

МЭДЭЭЛЭЛ, ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНД
БҮРЭН ХЭРЭГЖСЭН, ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ ХУУЛИЙН ЖАГСААЛТ**

/2016 оны жилийн эцсийн байдлаар/

№	Хуулийн нэр, огноо	Заалтын агуулга	Хэрэгжилт
1	<p align="center">Тагнуулын байгууллагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2015.07.09</p>	<p>10.5. Монгол улсын зэвсэгт хүчний дээд удирдлагыг цэрэг-улс төрийн болон цэрэг-стратегийн тагнуулын мэдээгээр хангах чиг үүргийг тагнуулын ерөнхий газрын цэргийн тагнуулын газар хэрэгжүүлэх бөгөөд тус газрын дүрэм, ажиллах журмыг тагнуулын ерөнхий газрын дарга, зэвсэгт хүчний жанжин штабын даргатай хамтран батална.</p> <p>10.6. Хил хамгаалах байгууллагын дээд удирдлагыг хил орчмын нөхцөл байдлын талаарх тагнуулын мэдээгээр хангах чиг үүргийг тагнуулын ерөнхий газрын хилийн тагнуулын газар хэрэгжүүлэх бөгөөд тус газрын дүрэм, ажиллах журмыг тагнуулын ерөнхий газрын дарга, хил хамгаалах байгууллагын даргатай хамтран батална.”</p>	<p>ТЕГ, ЗХЖШ-ын даргын хамтарсан тушаалаар “ТЕГ-ын ЦТГ-ын ажиллах дүрэм, журам”-ийг 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдөр баталж, үйл ажиллагаанд мөрдлөг болгон ажиллаж байна.Хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p> <p>ТЕГ, ХХЕГ-ын даргын хамтарсан тушаалаар “ТЕГ-ын ХТГ-ын ажиллах дүрэм, журам”-ийг 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдөр баталж, үйл ажиллагаанд мөрдлөг болгон ажиллаж байна.</p>
<p align="center">Нийт 1 хуулийн 2 заалтыг хяналтаас хасах саналтай байна.</p>			

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНД
БҮРЭН ХЭРЭГЖСЭН, ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ
УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ЖАГСААЛТ
/2016 оны жилийн эцсийн байдлаар/**

№	Тогтоолын нэр, огноо, дугаар	Заалтын агуулга	Хэрэгжилт
1	<p>Монгол Улсын төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлого батлах тухай</p> <p align="center">2009.06.25 №45</p>	<p>2. "Монгол Улсын төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлого"-ыг хэрэгжүүлэх хөтөлбөрийг боловсруулан баталж, тухайн жилд авч хэрэгжүүлэх арга хэмжээ, түүнд шаардагдах хөрөнгийг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл, улсын төсвийн төсөлд тусгаж байхыг Монгол Улсын Засгийн газарт даалгасугай.</p>	<p>Цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ, түүнд шаардагдах хөрөнгийг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэлийн төсөл болон улсын төсвийн төсөлд тусган ажиллаж байна.</p>
2	<p>Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого, хөтөлбөр батлах тухай</p> <p align="center">2011.05.13 №22</p>	<p>2. Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулан баталж, тухайн жилд авч хэрэгжүүлэх арга хэмжээ, түүнд шаардагдах хөрөнгийг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын төсөвт тусгаж байхыг Монгол Улсын Засгийн газар /С.Батболд/-т даалгасугай.</p>	<p>Монгол Улсын Их Хурлын “Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын төсөлд ЭХЯ-аас санал өгсөн.</p> <p>Уг төлөвлөгөөний 2.13-т “Газар хөдлөлтийн гамшгийн үед эрчим хүчний хангамжийг нэн тэргүүнд сэргээн босгох шаардлагатай дулааны станц, эмнэлэг, ус сувгийн газар, бохирын станц, гал команд, удирдлагын байр, холбоо, төв телевиз, нисэх буудал гэх мэт нэгдүгээр зэргийн хэрэглэгчдийг эрчим хүчээр хангах нөөц тэжээлийн эх үүсвэр /дизель станц/-тэй болох” гэснийг Монгол Улсын Засгийн газрын “Эрчим хүчний аюулгүйн нөөцийг бүрдүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 2015 оны 315 дугаар тогтоолоор шийдвэрлэсэн тул төлөвлөгөөнөөс хасах, Газар хөдлөлтийн гамшгийн үед гэмтсэн дулааны болон бохирын шугам хоолойг сэргээн засварлахад шугамын сувгаас ус зайлуулах насосыг улсын нөөцөд байлгах шаардлагатай байгаа тул төлөвлөгөөний 2.15-д заасныг хариуцах байгууллагыг “ОБЕГ, БХБЯ, ЭХЯ” гэж өөрчлөх эсвэл “Дулааны шугамд гарсан гэмтлийг сэргээн засварлах үед шугамын сувгаас</p>

			ус зайлуулах өндөр хүчин чадал бүхий насос авах” гэж өөрчлөх, төлөвлөгөөний нэгдүгээр хэсгийн 1.16-д “Эрчим хүчний хэрэглэгчийн зэрэглэл тогтоох журам”-ын төслийг боловсруулж Засгийн газрын хуралдаанд оруулах” /2016 он/ гэж нэмэх саналыг өгсөн.
3	Монгол Улсын цөмийн зэвсгээс ангид байх статусыг шинэ түвшинд гаргах тухай 2015.06.19 №09	1.1 Цөмийн зэвсэгтэй таван улс, “цөмийн зэвсэггүй бүсүүд ба Монгол улс”-ын бага хурал, эвсэлд үл нэгдэх хөдөлгөөн болон бүс нутгийн холбогдох байгууллагатай хамтран ажиллаж, нэгдсэн үндэстний байгууллагын ерөнхий ассамблейн болон бүс нутгийн баримт бичгүүдэд цөмийн зэвсгээс ангид байх тухай Монгол Улсын статус нь бүс нутгийн тогтвортой байдал болон итгэлцлийг бэхжүүлэхэд чухал хүчин зүйл болж байгааг тусгаж байх, улс төрийн хоёр талын баримт бичгүүдэд мөн санааг тусгаж дэмжүүлж байх, уг статусын ач холбогдлыг олон улсын хэмжээнд сурталчлан таниулах арга хэмжээг авч байх.	НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 71 дүгээр чуулганы 2016 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн бүгд хуралдаанаар Монгол Улсын олон улсын аюулгүй байдал, цөмийн зэвсэггүй статусын талаарх Ерөнхий Ассамблейн A/Res/71/43 тогтоолыг нийтийн зөвшилцлөөр баталсан. 2016 оны 9 дүгээр сард Венесуэлийн Маргарита аралд болсон ЭҮНХ-ий Дээд түвшний 17 дугаар уулзалтын төгсгөлийн баримт бичгийн 195 дугаар зүйлд манай улсын цөмийн зэвсэггүй статус болон уг статусыг эрхзүйн үндэстэй болгох тухай манай улсын санаачлагыг дэмжиж буйг илэрхийлсэн заалтыг тусгасан
		1.2 Монгол Улсын цөмийн зэвсгээс ангид байх тухай статусыг цаашид урагшлуулан бэхжүүлэхдээ бүс нутгийн тогтвортой, аюулгүй байдалтай холбох, зүүн хойд азид аюулгүй байдлын яриа хэлэлцээ явуулах тухай Монгол Улсын санаачилгын нэг чухал хүчин зүйл болгож ажиллах.	Монгол Улсын Засгийн газар, Филиппин Улсын Засгийн газар хамтран 2015 оны 9 дүгээр сарын 3-4-ний өдрүүдэд Улаанбаатар хотноо “Монгол Улсын Цөмийн зэвсэггүй статусыг сурталчлах нь” сэдэвт АСЕАН-ы бүсийн чуулга уулзалт /АРФ/-ын орнуудын шинжээчдийн түвшний семинарыг зохион байгуулсан. Арга хэмжээнд цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх, зэвсэг хураах, бүс нутгийн аюулгүй байдлын асуудал эрхэлсэн АРФ-ын гишүүн орнуудын шинжээчид, холбогдох байгууллагын удирдах албан тушаалтныг төлөөлсөн 20 гаруй төлөөлөгч оролцож харилцан туршлага судалсан. Зүүн хойд Азийн аюулгүй байдлын асуудлаарх “Улаанбаатарын яриа хэлэлцээ” олон улсын III Бага хурлыг 2016 оны 6 дугаар сарын 16-17-нд Улаанбаатар хотноо Гадаад хэргийн яам, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Стратегийн судалгааны хүрээлэн хамтран зохион байгуулав.

			<p>Бага хуралд БНХАУ, ОХУ, БНАСАУ, БНСУ, Япон, АНУ, Герман, Энэтхэг, Их Британи, Австрали, Францын эрдэмтэн судлаачид, НҮБ, Олон Улсын Улаан Загалмайн Хороо, Фридрих Эбертийн Сан зэрэг олон улсын байгууллагын төлөөлөгчид, мөн дотоодын төр, хувийн хэвшлийг төлөөлсөн 150 гаруй төлөөлөгч оролцож, ЗХА-ийн аюулгүй байдлын өнөөгийн байдал, учирч буй сорилт бэрхшээл, бүс нутагт харилцан ойлголцол, итгэлцэл бий болгох арга зам, ЗХА-ийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааг дэмжих асуудлаар хэлэлцүүлэг өрнүүлэв.</p> <p>Зэвсэгт мөргөлдөөнөөс урьдчилан сэргийлэхийн төлөө бүх нийтийн түншлэл (GPPAC) олон улсын байгууллагын Зүүн хойд Азийн бүс нутгийн орнуудын зохицуулах төвүүдийн дугуй ширээний уулзалт, ярилцлагыг 2016 оны 11 дүгээр сарын 14-16-нд Улаанбаатар хотноо “Зүүн хойд Азийн аюулгүй байдлын, түүний дотор цөмийн зэвсгээс ангид байх асуудал” сэдвийн хүрээнд зохион байгуулав. Арга хэмжээнд Орос, Хятад, Япон, БНАСАУ, БНСУ, АНУ, Монгол зэрэг улсын 20 гаруй судлаач оролцов.</p>
		2.Монгол Улсын цөмийн зэвсгээс ангид байх статус, энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасны дагуу хийж гүйцэтгэж байгаа ажлын талаар Монгол Улсын Их Хурлын аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд жил бүр мэдээлсүгэй.	Монгол Улсын цөмийн зэвсгээс ангид байх статусын дагуу хийж гүйцэтгэж байгаа ажлын талаар Монгол Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд жил бүр тайлагнасан.
4	<p>Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай</p> <p>2015.07.09 №76</p>	1.1 Зэвсэгт хүчний жанжин штабын цэргийн тагнуулын газар, хил хамгаалах ерөнхий газрын хилийн тагнуулын газрын орон тоо төсөв, гүйцэтгэх ажилтай холбогдох бие бүрэлдэхүүн, дэд бүтэц, барилга байгууламж, материал техникийн хангамж, зэвсэг хэрэгслийг 2015 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор тагнуулын ерөнхий газарт шилжүүлэх ажлыг зохион байгуулах.	Монгол Улсын Засгийн газрын 382 дугаар тогтоол, Төрийн өмчийн хорооны 630 дугаар тогтоолыг үндэслэн Батлан хамгаалахын сайдын Н/21 дүгээр тушаалаар Зэвсэгт хүчний Жанжин штабын Цэргийн тагнуулын газрын орон тоо, төсөв, гүйцэтгэх ажилтай холбогдох бие бүрэлдэхүүн, дэд бүтэц, барилга байгууламж, материал техникийн хангамж, зэвсэг хэрэгслийг 2015 оны 12 дугаар сарын 1-нд Тагнуулын Ерөнхий газарт шилжүүлсэн.
5	Газар хөдлөлтийн	8. “Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан	“Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх,

<p>гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай</p> <p>2016.04.14 №34</p>	<p>сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө"-г батлан, төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний зардлыг жил бүрийн улсын төсөвт тусган шийдвэрлүүлж байх.</p>	<p>эрсдлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө"-ний төслийг боловсруулж, Засгийн газрын 2016 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 282 дугаар тогтоолоор батлуулсан.</p>
--	---	---

Нийт 5 тогтоолын 7 заалтыг хяналтаас хасах саналтай байна.

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
БҮРЭН ХЭРЭГЖСЭН, ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ ТОГТООЛЫН ЖАГСААЛТ**
/2016 оны жилийн эцсийн байдлаар/

№	Тогтоолын нэр, огноо, дугаар	Заалтын агуулга	Хэрэгжилт
1	<p align="center">Хуулийн хэрэгжилтийг хангах, зөрчлийг арилгах асуудлаар чиглэл өгөх тухай</p> <p align="center">2009.06.17 №04</p>	<p>4. Монгол Улсын "Далай ашиглах" хуулийг чанд мөрдөж ажиллах, хуулийн хэрэгжилтийг хангах бололцоотой арга хэмжээг авч хэрэгжүүлэх.</p>	<p>Далай ашиглах тухай хуулийг чанд мөрдөн ажиллаж байна. Далай ашиглах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалын төслийг Засгийн газрын 09 дүгээр сарын 21-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн ба Засгийн газрын гишүүдээс гаргасан саналын дагуу "Монголын хөлөг онгоцны бүртгэл" компанийн үйл ажиллагааг шалгаж, дүрэм журам болон хөлөг онгоц бүртгэх шалгуурыг боловсронгуй болгох, бүртгэлтэй хөлөг онгоцонд тавих хяналтыг чангатгах арга хэмжээ авч, энэ талаар үзэл баримтлалын төсөлд тусган дахин боловсруулж, хэлэлцүүлэхээр хойшлуулав. Монголын хөлөг онгоцны бүртгэлийн компанид бүртгүүлэхээр хүсэлт гаргасан хөлөг онгоцнуудад хяналт тавьж ажиллаж байна.</p> <p>Сингапурын "МХОБ" Сенат шиппинг, Сингкласс Далайн захиргаа хоорондын гэрээ 2015 оны 02 дугаар сарын 15-ны өдрөөр дуусгавар болж, гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулан дахин байгуулсан.</p>
2	<p align="center">Чиглэл өгөх тухай</p> <p align="center">2012.12.20 №05</p>	<p>2. Хилийн чанадад үндэсний болон иргэдийн эрх ашгийг хамгаалах чадавхийг нэмэгдүүлэх, консулын албыг бэхжүүлэх үүднээс дипломат төлөөлөгчийн газруудын байршил, бүтэц, орон тоог оновчтой болгох асуудлыг шийдвэрлэх.</p> <p>5. "Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сан"-гийн үйл ажиллагааг иргэдэд илүү хүртээмжтэй, боловсронгуй</p>	<p>Одоогоор Монгол Улсаас гадаад улсад суугаа 46 ДТГ-ын 9 нь ЕКГ (Эрхүү, Улаан-Үд, Истанбул, Кызыл, Хонконг, Хөх хот, Эрээн, Бишкек, Сан Франциско), 4 нь Консулын газар (Пусан, Эрээн, Хайлаар, Алматы) байна. Мөн 6 ДТГ (Москва, Бээжин, Вашингтон, Берлин,Токио, Сөүл) Консулын хэлтэстэй үйл ажиллагаа явуулж байна. Манай улсад гадаадын 3 ЕКГ үйл ажиллагаа явуулж байна. (Эрдэнэт, Дархан дахь ОХУ-ын ЕКГ, Замын-Үүд дахь БНХАУ-ын ЕКГ). Консулын албыг өргөжүүлэх хүрээнд БНХАУ-ын Шанхай, АНУ-ын Чикаго, Канад улсын Ванкүвер хотод тус тус консулын газар нээх асуудлыг судалж байна.</p> <p>2016 онд "Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сан"-д улсын төсвөөс 224,0 сая төгрөг төсөвлөгдсөн. 2016 онд Хилийн чанадад Монгол иргэдэд туслах сангийн</p>

		болгох, санхүүжилтийг нэмэгдүүлэх талаар арга хэмжээ авч ажиллах.	зөвлөлийн хурлыг 3 удаа зохион байгуулж нийтдээ иргэний 30 өргөдөл, ДТГ-ын 39 хүсэлтийг хэлэлцэж, 222,781,200 төгрөгийг зарцуулсан. Мөн өмнөх онд шийдвэр нь гарсан боловч санхүүжилт хийгдээгүйн улмаас олгогдоогүй байсан 56 сая төгрөгийн тусламжийг 2016 оны төсвөөс нөхөн олгосон байна.
3	Чиглэл өгөх тухай 2013.04.10 №04	1. Монгол Улсаас ХБНГУ-д суугаа элчин сайдын яаманд ашиглахаар берлин хотын төвд 2012 онд худалдан авсан талбай дээр нэмж 2 дугаар давхрын 100м2 талбайг худалдан авах хөрөнгийг 2013 оны төсөвт тусгах.	Монгол Улсаас ХБНГУ-д суугаа Элчин сайдын яамны барилгын өргөтөл хийхэд 2015 оны хөрөнгө оруулалтын төсөвт 1050,0 сая төгрөг тусгагдаж 2015 оны 7 дугаар сард 1008.2 сая төгрөгөөр тус байрыг худалдан авсан.
4	Гадаад бодлогын шийдвэр гаргах тогтолцоог боловсронгуй болгох талаар чиглэл өгөх тухай 2014.06.27 №06	1.2. Гадаад бодлогын нэгдсэн зохицуулалтыг хангах үүднээс гадаад харилцааны яамны бүтцэд мэдээлэл солилцоо, төрийн гадаад үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, хяналтыг хариуцсан нэгж байгуулан бэхжүүлэх.	Засгийн газрын 2016 оны 7 дугаар сарын 27-ны өдрийн "Яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар байгуулах тухай" 3 тоот тогтоолоор ГХЯ-ны Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газрыг байгуулан ажиллаж байна.
		1.3.Гадаад харилцааны яамны мэдээлэл боловсруулах, судалгаа, дүн шинжилгээ хийх, бодлого боловсруулах чадавхыг бэхжүүлэх зорилгоор холбогдох нэгжийн орон тоо, зохион байгуулалтыг оновчтой болгох, гадаад бодлого боловсруулах, холбогдох мэдээлэл бэлтгэх үе шат бүрд тухайн нэгжийн оролцоог хангасан зохицуулалтыг бий болгох.	ГХЯ нь Засгийн газрын 2016 оны 7 дугаар сарын 27-ны өдрийн "Яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар байгуулах тухай" 3 тоот тогтоолын дагуу шинэ батлагдсан бүтэцээр зохион байгуулагдан ажиллаж байна.
		2.1 .Монгол Улсын гадаад бодлого, үйл ажиллагааны талаарх мэдээлэл, танилцуулгыг байнгын хороонд улирал тутуам ирүүлж байх	Монгол Улсын гадаад бодлого, үйл ажиллагааны талаарх мэдээлэл, танилцуулгыг болон АБГБХ-ны 2011 оны 5, 2012 оны 5, 2014 оны 06, 2015 оны 2 тоот тогтоолуудын биелэлтүүдийг Байнгын хороонд улирал тутам хүргүүлж байна.

		2.2.Тогтоолын хэрэгжилтийн явцын талаарх мэдээллийг 2014 оны 11 дүгээр сарын эхний долоо хоногт багтаан аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд ирүүлэх, тогтоолын биелэлтийг 2015 оны 01 дүгээр сарын эхний хагаст багтаан тус байнгын хорооны хуралдаанд танилцуулах.	Тогтоолын хэрэгжилтийн явцын талаарх мэдээллийг 2014 оны 11 дүгээр сарын эхний долоо хоногт багтаан Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд, тогтоолын биелэлтийг 2015 оны 01 дүгээр сарын эхний хагаст багтаан Байнгын хорооны хуралдаанд танилцуулсан.
5	Чиглэл өгөх тухай 2015.01.14 №02	1.8. "Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сан"-гийн үйл ажиллагааг иргэдэд илүү хүртээмжтэй болгох, үүнд зориулах хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлж, жил бүрийн төсөвт тусгах. 1.9. Монгол Улсын түүх, соёлын уламжлал, эдийн засаг, нийгмийн салбарын ололтыг гадаадад сурталчилах ажлыг идэвхжүүлэх, энэ үүднээс "Монгол Улсыг гадаадад сурталчилах хөтөлбөр"-ийг боловсруулж батлан, шаардагдах хөрөнгө, санхүүгийн асуудлыг шийдвэрлэж байх.	2016 онд "Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сан"-д улсын төсвөөс 224,0 сая төгрөг төсөвлөгдсөн. 2016 онд хилийн чанадад Монгол иргэдэд туслах сангийн зөвлөлийн хурлыг 3 удаа зохион байгуулж нийтдээ иргэний 30 өргөдөл, ДТГ-ын 39 хүсэлтийг хэлэлцэж, 222,781,200 төгрөгийг зарцуулсан. Мөн өмнөх онд шийдвэр нь гарсан боловч санхүүжилт хийгдээгүйн улмаас олгогдоогүй байсан 56 сая төгрөгийн тусламжийг 2016 оны төсвөөс нөхөн олгосон байна. 2017 оны хувьд өмнөх жилүүдийн адил 224,0 сая төгрөг төсөвлөгдсөн. "Монгол Улсыг гадаадад сурталчилах хөтөлбөр"-ийг боловсруулж Засгийн газрын хуралдаанар хэлэлцүүлэн батлуулав.
6	Чиглэл өгөх тухай 2015.05.29 №09	1. "Оюу толгой ккх-ийн анхны хөрөнгө оруулалтын зардлын хэтрэлтийг шалгасан дүн" болон 2015 оны 05 дугаар сарын 18-ны өдөр гарын үсэг зурсан "оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн төлөвлөгөө"-ний талаарх нэгтгэсэн мэдээлэл болон Улсын Их Хурлын 2009 оны 57 дугаар тогтоолын биелэлтийг 2015 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Улсын Их Хуралд танилцуулах. 2. 2009 оны 10 дугаар сарын 06-ны өдөр гарын үсэг зурсан оюу толгойн хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсантай	Уг заалтын дагуу 2015 онд Улсын Их Хуралд танилцуулсан болно. "Оюу толгой төслийн далд уурхайн бүтээн байгуулалтыг түргэтгэх, уг төслийн хэрэгжилтэд Засгийн газраас бодлогын дэмжлэг үзүүлэх чиглэлээр танилцуулга бэлдэж 2014 оны 6-р

		<p>холбогдуулан Монгол Улс цаашид томоохон төсөл, хөтөлбөрийг үндэстэн дамнасан компанитай хамтран хэрэгжүүлэхэд Засгийн газрын зүгээс анхаарах асуудал, хүний нөөцийн бэлэн байдал, хууль тогтоомжийг боловсронгуй болгох, гэрээ, хэлэлцээр хийхэд анхаарах асуудал зэрэг сургамжуудыг тодруулан цаашид авч хэрэгжүүлэх бодлогын талаарх мэдээллийг Улсын Их Хуралд танилцуулах.</p>	<p>сарын 14-ний өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн. Мөн ЗГ-ын хуралдаанаас өгсөн үүргийн дагуу Ерөнхий сайдад танилцуулж, 2014 оны 6-р сарын 18-ны өдрийн хуралдаанаар дахин хэлэлцүүлэхээр холбогдох материалыг ЗГ-т хүргүүлж хэлэлцүүлсэн. Хөрөнгө оруулагчийн зүгээс Санамж бичиг байгуулах хүсэлт гаргасан бөгөөд шинээр байгуулагдсан Засгийн газрын төсөл, хөтөлбөр хариуцсан сайд хариуцан ажиллаж байна.</p> <ul style="list-style-type: none"> - Ордын техник, эдийн засгийн үндэслэлд тодотгол хийж, тайланг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2015 оны 9 дүгээр сарын хуралдаанаар хэлэлцүүлж батлуулсан. - Оюутолгой төслийн хөрөнгө оруулагч талтай хэлэлцээ хийх Ажлын хэсгийн хүрээнд “Оюутолгойн далд уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн төлөвлөгөө”-г боловсруулж 2015 оны 5 дугаар сард Дубай хотод талууд /Монголын талаас “Эрдэнэс Монгол” ХХК, “Эрдэнэс Оюутолгой” ХХК, хөрөнгө оруулагч талаас Туркойс Хилл Ресурсес Лимитед болон Рио Тинто Интернэшнл Холдингс Лимитед компаниуд/ гарын үсэг зурсан. - Мөн Оюутолгой төслийн далд уурхайн санхүүжилтийн гэрээнд 2015 оны 12 дугаар сарын 16-нд гарын үсэг зурж, дэлхийн томоохон 20 банк, санхүүгийн байгууллага Оюутолгой төсөлд 4.4 тэрбум ам.долларын зээл олгох болсон.
<p>Нийт 6 тогтоолын 12 заалтыг хяналтаас хасах саналтай байна.</p>			